



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ  
УЛААНХУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/44

Билүү төв


Ерөнхий зориулалтын мэргэжлийн анги  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21, Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.8, 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтууд, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалаар батлагдсан Мэргэжлийн ангийн дүрмийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бүтэц, бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг гаргаж мэргэжлийн ангийг удирдан чиглүүлж, мэргэжлийн арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэн зохион байгуулалтаар хангаж ажиллахыг мэргэжлийн ангийн дарга /А.Хонырат/-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/21 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  К.БАГДАУЛЕТ